



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/1302

Улаанбаатар хот

Өр барагдуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Татан буугдсан “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын өр төлбөрийг төлж барагдуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

2.Үйлдвэрийн газрын өр төлбөрийг барагдуулахад шаардагдах нийт 93,063,400.0 (ерэн гурван сая жаран гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг Нийслэлийн 2024 оны төсвийн нэмэлт өөрчлөлтөд тусгасан холбогдох зардлаас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205872

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
...<sup>21</sup>... дугаар сарын 25-ний өдрийн  
...<sup>А/1302</sup>... дугаар... захирамжийн  
хавсралт

ӨР ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

(төгрөгөөр)

Д/д	Байгууллагын нэр	Өр төлбөрийн дүн	Тайлбар
1	Татварын өр	36,181,547.98	2020 оноос хойших нэмэгдсэн өртгийн албан татвар, цалин хөлс, үл хөдлөх хөрөнгийн татвар
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр	10,295,275.07	2022 оны 4 дүгээр сараас 2023 оны 07 дугаар сарын 31-нийг хүртэлх нийгмийн даатгалын шимтгэлийн өр
3	“Санхүүгийн тооцоолох групп” ХХК	383,000.00	2023 оны лицензийн төлбөр
4	Нийслэлийн Архивын газар	56,500.00	Архиваас 2022 оны баримт авсны төлбөр
5	“Гэрэлт хөх тэнцвэр” ХХК	16,500,000.00	2020, 2021, 2022 оны аудитын төлбөр
6	“Монгол даатгал” ХХК	152,437.00	Автомашинны 2022 оны даатгалын хураамж
7	“Аркиже инженеринг” ХХК	200,000.00	2023 оны газрын кадастрын төлбөр
8	“Нью компас кей” ХХК	66,000.00	Тоон гарын үсэг, гэрээ сунгуулсан 2023 оны төлбөр
9	Ажилчдын цалин	26,553,323.78	2022 оны 07 дугаар сараас 2023 оны 08 дугаар сар хүртэлх хугацааны цалин
10	Ажилчдад өглөг	2,675,270.00	2021-2023 онд үүссэн ажилчдын өр төлбөр /С.Эрдэнэчимэгийн ажилгүйдлийн тэтгэмж 1,478,770.0 төгрөг, бичиг хэрэгт 202,500.0 төгрөг, машины сэлбэг шатахуун, оношилгооны төлбөр 994,000.0 төгрөг/
	Нийт дүн	93,063,400.00	